ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХАНХ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 06 өдөр Дугаар 15 Турт

Сонгуулийн хэсэг нэгтгэх тухай

Монгол Улсын Сонгуулийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэхь заалтыг үндэслэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1.Сонгуулийн ерөнхий хорооны 2017 оны 5 дугаар сарын 04 ны өдрийн 20 тоот "Зөвшөөрөл олгох" тухай шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор 2017 оны Монгол улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн сумандаа зохион байгуулж явуулахаар байгуулагдсан Тураг 1-р баг 1467 хэсгийг Турт 3-р баг 1469 хэсэгтэй нэгтгэн байгуулж, хэсгийн төв нутаг дэвсгэр, хэсгийн нэршил, сонгогчдын тоог дор дурдсанаар баталсугай.

№	Хэсгийн дугаар	Нутаг дэвсгэр	Хэсгийн төв \нэршил\	Санал авах байрны байршид	Сонгогчийн тоо
1	.....	Ханх	1, 3-р баг Тураг Турт	Сумын Соёлын төв	1556

2. Хэсэг нэгтгэх тухай" шийдвэрийг хуулийн хугацаанд аймгийн улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлж холбогдох албан тушаалтан иргэд сонгогчдод мэдээлж ажиллахыг сумын ИТХ-ын дарга Л.Дуламхүү улсын бүртгэгч Р.Нэргүй нарт даалгасугай.

3. Тогтоол гарсантай холбогдуулан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 02 дугаар сарын 07 ны өдрийн 03 тоот тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА Л.ДУЛАМХҮҮ

4123683 ГСҮ0102

Document- togtool A-4 2017